

Нэгдсэн хуралдаанд
Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хугацаа тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.3.1, 5.4.7 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүнээс өргөн мэдүүлсэн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг судлах, уг төслийг саналын түвшинд харгалзан үзэх, хэлэлцүүлэх, зөвшилцэх шаардлагатай байх тул Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хугацааг 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуустал тогтоосугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг